

Санхүүгийн хяналт шалгалт хийсэн дүнгийн тухай

НЭГ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО

Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт аудитын албаны 2019 оны хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу Хялганат тосгоны бүрэн дунд сургуулийн 2018 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд Монгол Улсын Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Боловсролын тухай хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актуудын хэрэгжилтийг шалгаж, зөрчил дутагдал илэрсэн тохиолдолд холбогдох хуулийн дагуу шийдвэрлэх, аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх, цаашид давтан гаргахгүй байх талаар мэргэжил арга зүйн заавар, зөвлөгөө өгөхөд оршино.

ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА

Булган аймгийн Засаг даргын баталсан 2019 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 1/12 дугаар удирдамжийн дагуу хяналт шалгалтыг Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч Ж.Оюун 2019 оны 06 дугаар сарын 13-аас хуанлын 5 хоногт багтаан төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж гүйцэтгэв.

ГУРАВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

Хялганат тосгоны бүрэн дунд сургуулийн 2018 оны касс, харилцах дансны гүйлгээг санхүүгийн анхан шатны баримттай тулган шалгасны зэрэгцээ цалин хөлс, олговор, тэтгэмж, шагнал урамшуулал, албан томилолтын бодолт, олголт, нэмэлт орлого түүний бүрдүүлэлт, зарцуулалт, хүнсний бүтээгдэхүүн, бараа материалын худалдан авалт, зарцуулалт, үлдэгдлийн байдал, шатахууны олголт, зарцуулалт, хэтрэлт хэмнэлт, эд хөрөнгийн тооллого тооцоо бодолт, санхүү, төсвийн ил тод байдлын хэрэгжилт, “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилт зэрэг хяналт шалгалтын удирдамжид заагдсан асуудлуудыг хамруулав.

ДӨРӨВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН ОБЪЕКТЫН ТАЛААРХ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Хангал сумын дөрөвдүгээр багт байрлах 9011323 регистрийн дугаартай Хялганат тосгоны бүрэн дунд сургууль нь захирал 1, сургалтын менежер 2, нийгмийн ажилтан 1, насан туршийн боловсролын багш 1, сургуулийн эмч 1, бага ангийн багш 14, дунд ангийн багш 24, нягтлан бодогч 1, номын санч бичиг хэрэг 1, нярав, архивч 1, дотуур

байрны тогооч 2, үдийн цайны тогооч 1, дотуур байр болон үдийн цайны туслах тогооч 3, гал тогооны үйлчлэгч 1, дотуур байрны багш 2, дотуур байрны жижүүр 4, сургуулийн үйлчлэгч 6, сургуулийн жижүүр 4, слесарь 1, гэсэн 72 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж ирсэн байна.

Тус тосгоны бүрэн дунд сургуулийн 2018 оны 01 сарын 01-ээс 2018 оны 12 сарын 31-ний өдрийг хүртэлх хугацааны нэгдүгээр гарын үсгийг захирал Ч.Алтанцацралт, хоёрдугаар гарын үсгийг нягтлан бодогч Ё.Эрдэнээ нар зурж, төрийн санд бүртгэлийн 100041715101 дугаар, нэмэлт санхүүжилтийн 100041715401 дугаар данстайгаар хөрөнгө мөнгийг захиран зарцуулж ирсэн ба нягтлан бодох бүртгэлийг санхүүгийн тооцоолох "CTS" программаар бүртгэж хөтөлсөн байна.

Шалгалтанд хамрагдсан хугацаанд тус байгууллагын няраваар Д.Оюунчимэг ажилласан байна.

ТАВ. ӨМНӨХ ШАЛГАЛТЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Хангал сумын Хялганат тосгоны бүрэн дунд сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан нь аудитын түүвэрт хамрагдсан ба тайлант оны санхүүгийн үйл ажиллагаанд бусад байгууллагаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

ЗУРГАА. ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЛААР

Хялганат тосгоны захирагчийн захирамжаар Санхүүгийн албаны дарга Б.Эрдэнэбаатараар ахлуулсан 5 хүний бүрэлдэхүүнтэй дотоод хяналт шалгалт хийх ажлын хэсгийг байгуулж, бүрэн дунд сургуулийн 2018 оны эхний 9 сарын цалин хөлс, нэмэгдэл урамшууллын бодолт, олголт, гүйцэтгэлийн байдал, орон тоо бүтэц, шатахууны зарцуулалт, Татвар, НДШимтгэлийн тайланд дотоодын хяналт шалгалтыг хийсэн байна.

Уг шалгалтаар сар бүр цагийн тооцоог гарган батлуулж цалин хөлсийг заавар журмын дагуу бодож олгосон байна. Үдийн цай, хоолны зардлын хүнсний бүтээгдэхүүнийг журмын дагуу худалдан авахад анхаарах, багш, ажиллагсдын цалингаас хоолны үнэ, засварын материалын үнэ, хувцасны үнэ, махны үнэ зэрэг суутгалуудыг суутгаж зарцуулсан, суутгалыг зарим ажилчид нь хүлээн зөвшөөрөөгүй, цаашид цалингаас суутгал хийхгүй байхыг анхааруулж зөвлөсөн байна.

Мөн тус тосгоны Эрүүл мэндийн төвийн нягтлан бодогч Ч.Баасансүрэн бүрэн дунд сургуулийн 1-3 сарын анхан шатны баримтын бүрдэлт, шатахуун, цалин, томилолтын зардалд дотоодын хяналт шалгалтыг хийсэн байна.

ДОЛОО. ШИЛЭН ДАНСНЫ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Шилэн дансны нэгдсэн сайтад Хялганат тосгоны бүрэн дунд сургууль нь 2018 онд мэдээлбэл зохих 149 мэдээллээс 147 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж, 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

НАЙМ. ШАЛГАЛТЫН ЯВЦАД ХИЙГДСЭН АЖИЛ, ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

Тус тосгоны бүрэн дунд сургуулийн 2018 оны касс, харилцах, аж ахуйн баримт, өмч хөрөнгийн бүртгэл, байгууллагын удирдлагын гаргасан шийдвэр, хөдөлмөрийн дотоод журам, цалингийн карт, ажлын цаг ашиглалтын бүртгэл, хүнсний агуулахын

бүртгэл, багшийн журнал, дотуур байрны багшийн бүртгэл, тайлан баланс, дотоод хяналт хийсэн шалгалтын материал зэрэг баримт материалуудад тулгуурлан нягтлан бодогч Ё.Эрдэнээ нарыг байлцуулан төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийв.

Нярав Д.Оюунчимэг нь гачигдал гарч, шалгалтад хамрагдаагүй болно.

8.1. Санхүүгийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаар:

2018 онд улсын төсвөөс 1,091,678.6 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөж санхүүжилтийг бүрэн авсан, нэмэлт санхүүжилтийн дансаар 2,746.7 мянган төгрөг бүгд 1,094,425.2 мянган төгрөгийн эх үүсвэртэй ажилласан байна.

Төсөвт зардлыг 1,091,678.5 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардалд 579,593.1 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 69,819.0 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 301,588.3 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 8,620.8 мянган төгрөг, нормативт зардалд 48,398.2 мянган төгрөг, урсгал засварын зардалд 4,158.4 мянган төгрөг, дотоод албан томилолтын зардалд 431.6 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 1,090.1 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 6,454.0 мянган төгрөг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад таван жил тутамд олгох тэтгэмжид 13,361.4 мянган төгрөг, тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн тэтгэмжид 18,252.0 мянган төгрөг, үдий цайны зардалд 27,161.9 мянган төгрөг, төсвийн дотоод эх үүсвэрээр дотуур байрны өмнөх шороон талбайд өнгөт хавтан суулгах, тавилга эд хогшил худалдан авахад 10,440.0 мянган төгрөг нийт 1,089,368.8 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 2309.7 мянган төгрөг (цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 2,791.1 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 66.7 мянган төгрөг)-ийг буцаан төвлөрүүлсэн байна.

Дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг 46317.4 мянган төгрөгөөр төлөвлөж 17963 хүүхэд өдөрт 41792.8 мянган төгрөгийн хүнс зарцуулж нэг хүүхдэд өдөрт 2327 төгрөгийн хоол, үдийн цайны зардлыг 27,161.9 мянган төгрөгөөр төлөвлөж 45171 хүүхэд өдөрт 27094.7 мянган төгрөгийн хүнс зарцуулж нэг хүүхдэд өдөрт дунджаар 599.8 төгрөгийн хоол хүнс олгосон байна.

Булган аймаг байгуулагдсаны 80 жилийн ойд тус тосгоны бүрэн дунд сургуулийн багш, ажиллагсад 3 өдрийн цалин 3668.5 мянган төгрөг хандивлажээ.

Нэмэлт санхүүжилтийн талаар:

2018 оны 02 сард Канад сангийн төслийн 1276.8 мянган төгрөг, 03 сард БСУГазраас тэтгэлэгт хөтөлбөрийн 1469.9 мянган төгрөг нийт 2,746.7 мянган төгрөгийн орлого орсон байна. Хас Оргил ХХК-иас 1276.8 мянган төгрөгөөр монгол хэл, уран зохиол зэрэг хичээлийн үзүүлэнгийн материал худалдан авч, бичиг хэргийн материалын тайланд орлогод авч, зарцуулсан байна.

Булган аймгийн “Ахмад багш нарын холбоо”-оос тус сургуулийн багш, ажиллагсад, эцэг, эхчүүд, суралцагч нарт “Тайлбартай дасгалын арга”, “Суу ухаан, арга билэг” сэдэвт сургалт, гадаад улсад зохион байгуулсан олимпийн сургалтын зардалд 1469.9 мянган төгрөг зарцуулсан байна.

Тэтгэмжийн талаар:

Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.4 дахь заалтын дагуу биеийн тамирын багш Д.Ганхүүд 18252.0 мянган төгрөгийн тэтгэвэрт гарахад нь олгох тэтгэмж, мөн хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.7а дахь заалтын дагуу багш Б.Баярмаад 3237.0 мянган төгрөг, Ч.Саранцэцэгт 3237.0 мянган төгрөг, Ц.Энхтуяад 3237.0 мянган төгрөг, Б.Сурмаажавт 3650.4 мянган төгрөг бүгд 13361.4 мянган төгрөгийн хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны нэг удаагийн тэтгэмжийг тус тус олгожээ.

Хөдөлмөрийн чадвар түр алдсан 12 багшид 2057.4 мянган төгрөгийн, жирэмсэн амаржсан 5 эхэд 13,364.5 мянган төгрөгийн тэтгэмж олгосон байна.

Цалин хөлс, нэмэгдэл, урамшууллын талаар:

Захирал Ч.Алтанцацралтад аймгийн Засаг даргын 2018 оны Б/46, А/574 дугаар захирамжаар 01-12 сард үндсэн цалингийн 20-25 хувиар 2081.6 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл, аймгийн Засаг даргын 2018 оны А/233, А/583, А/696, А/712 дугаар захирамжаар 1-4-р улиралд үндсэн цалингийн 25-45 хувиар тооцож 1142.2 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулалт цалин, Хялганат тосгоны захирагчийн 2017 оны 12 сарын ...-ны өдрийн ... дугаар, 2018 оны 12 сарын 20-ны өдрийн Б/31 дугаар захирамжуудыг үндэслэн төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтээр 100 хувь дүгнэгдсэнд нэг сарын үндсэн цалин 1515.0 мянган төгрөгөөр урамшуулсан байна.

Хялганат тосгоны бүрэн дунд сургуулийн захирлын Б/19, Б/30, Б/41, Б/61 дугаар тушаалуудыг үндэслэн 1-р улиралд 59 албан хаагчид 10-51 хувиар тооцож 10,205.2 мянган төгрөг, 2-р улиралд 59 албан хаагчид 10-45 хувиар тооцож 9,895.1 мянган төгрөг, 3-р улиралд 58 албан хаагчид 6-45 хувиар тооцож 5,845.1 мянган төгрөг, 4-р улиралд 66 албан хаагчид 20-60 хувиар тооцож 20,481.2 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулалт цалин олгожээ.

Тайланд онд багш, ажиллагсдад үндсэн цалингийн 10-30 хувиар тооцож нийт 11,413.5 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл, 22,230.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгаа олгож бүрэн барагдуулсан байна.

Багш ажиллагсдын цалингаас Татвар, ЭМНДШимтгэл, цалингийн урьдчилгаанаас бусад дараах суутгалуудыг суутгасан байна Үүнд.

- ✓ Булган аймгийн 80 жилийн ойн хандивт 3 өдрийн цалин 3668.5 мянган төгрөг
- ✓ Багш, ажиллагсдаас хогны мөнгө сар бүр 2.0 мянган төгрөг буюу 1230.0 мянган төгрөг
- ✓ Сар шинийн баярыг тохиолдуулан иргэн Т.Алтанцогтоос 321.8 кг буюу 1930.8 мянган төгрөгийн мах зээлээр авч байгууллагын 10 албан хаагчид зээлээр олгож, амралтын цалингаас суутгасан
- ✓ Багш, ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор байгууллагын гал тогоонд аарц, бууз хийж, багш ажиллагсдад бууз 500 төгрөг, аарц 300 төгрөгөөр худалдаж, бууз аарцны үнэ 2167.1 мянган төгрөгийг цалингаас суутгаж, шилжүүлсэн.

- ✓ Цэргийн баярын өдрийг тэмдэглэхээр багш, ажиллагсдаас тус бүр 25.0 мянган төгрөг буюу нийт 1275.0 мянган төгрөгийг цалингаас суутгаж, няравын дансаар дамжуулан шилжүүлсэн.
- ✓ Байгууллагын ажилтаны шинэ байшингийн цайллага, багш, ажилтаны ар гэрт гарсан гачигдалд 95.0 мянган төгрөг.

8.2 Өглөг, авлагын талаар:

2018 онд өглөг, авлагагүй тайлан баланс гаргасан байна.

8.3. Үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлт:

№	Нэр	Мөнгөн дүн /төгрөгөөр/			
		Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
1	Барилга байгууламж	2,569,783,178	134,920,970.82	1,259,482,336.26	1,445,221,812.56
2	Авто тээврийн хэрэгсэл	5,500,000		5,500,000	
3	Машин тоног төхөөрөмж	261,816,441.74		33,496,446.69	228,319,995.05
4	Тавилга, эд хогшил	139,337,176.06	11,804,700	90,352,200	60,789,676
5	Бусад үндсэн хөрөнгө (ном)	4,228,875			4,228,875
6	Программ хангамж	50,000	200,000		250,000
7	Газар		63,262,000		63,262,000
	Дүн	2,980,715,670.80	210,187,670.82	1,388,830,982.95	1,802,072,358.67

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 5000.0 мянган төгрөгөөр багш нарын өрөөнд ширээ, сандал, 2 ш номын шүүгээ, 10 ш сандал худалдан авсан, 200.0 мянган төгрөгөөр няравын программ суулгасан, 5240.0 мянган төгрөгөөр дотуур байрны өмнөх талбайг тохижуулсан, БСШУСЯ-наас хэрэгжүүлж буй “Боловсролын чанарын шинэчлэл” төслийн хүрээнд 3,248.7 мянган төгрөгөөр 13 ш номын тавиур, бага ангийн STEM-ийн сургалтанд зориулж 672.0 мянган төгрөгөөр 6 ш ширээ, 1,344.0 мянган төгрөгөөр 24 ш сандал, БСШУСЯамны хөрөнгө оруулалтаар захирлын өрөөнд 1540.0 мянган төгрөгөөр бичиг хэргийн төмөр шүүгээ, номын шүүгээ, хувцасны шүүгээ, ширээ, угтвар ширээ, 6 ш сандал, эргэдэг сандал үнэ төлбөргүйгээр өгсөн байна.

Бусад хангамжийн материалын тайланд тусгагдсан байсан 8611.9 мянган төгрөгийн үнэ бүхий дотуур байрны өмнөх талбайн өнгөт хавтанг шилжүүлэн авч бүртгэсэн байна.

Засгийн газрын тогтоолын дагуу эргэлтийн бус хөрөнгө болох газар, барилга байгууламжид дахин үнэлгээг хийсэн байна.

Булган аймгийн ИТХурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 06 сарын 07-ны өдрийн 69 дугаар тогтоолоор 5,500.0 мянган төгрөгийн балансын үнэтэй “Истана” маркийн 78-30 БУА улсын дугаартай микроавтобусыг, Хялганат багийн Иргэдийн нийтийн хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 12 сарын 24-ний өдрийн 34 дүгээр тогтоолоор элэгдлийн хугацаа дуусч дахин ашиглах боломжгүй болсон 34 нэр төрлийн 33,496.4 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 27 нэр төрлийн 90,352.2 мянган төгрөгийн тавилга, эд хогшлыг актлан данс бүртгэлээс хассан байна.

8.4. Бараа материалын хөдлөл өөрчлөлт:

№	Үзүүлэлт	Мөнгөн дүн /төгрөгөөр/			
		Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
1	Бичиг хэрэг	14,373,448	4,175,443.10	3,439,893.10	15,108,998
2	Үдийн цай	4,127,234	27,161,900	27,094,714	4,194,420
3	Аж ахуй	29,899,832	11,688,500	17,749,996	23,838,336
4	Түлш шатах тослох		2,278,200	2,278,200	
5	Барилгын засвар		840,000	840,000	
6	Хүнс	9,527,900	46,317,400	41,792,780	14,052,520
7	Эм боох материал	128,800	354,600	341,450	141,950
8	Сэлбэг хэрэгсэл	950,000	60,000	470,000	540,000
9	Бэлэн бүтээгдэхүүн	3,675,186	100,000	262,500	3,512,686
10	Бусад хангамж	8,611,900	4,723,900	13,335,800	
	Дүн	71,294,300	97,699,943.10	107,605,333.10	61,388,910

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 95,179.9 мянган төгрөгийн бараа материал, ажилчдын үр дүнгийн урамшуулалт цалингаас суутган авсан 2520.0 мянган төгрөгөөр Орхон аймгийн иргэн Мядагмаагаас урсгал засварын материал тус тус худалдан авч, 8611.9 мянган төгрөгийн үнэ бүхий дотуур байрны өмнөх талбайн өнгөт хавтанг бусад хангамжийн материалын дансанд буруу бүртгэсэн байсныг залруулж үндсэн хөрөнгийн барилга байгууламжийн дансанд шилжүүлж, бүртгэсэн.

ЕС. ШАЛГУУЛАГЧИЙН ОЛОЛТТОЙ БОЛОН ДЭВШИЛТТЭЙ ТАЛ

Анхан шатны баримт, баримтын бүрдүүлэлт, нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт хангалттай, санхүүгийн тайлан, мэдээг хугацаанд нь гаргаж холбогдох байгууллагаар хянуулан баталгаажуулсан, үндсэн хөрөнгө хүлээн авах бүрдээ “Үндсэн хөрөнгө хүлээн авах, шилжүүлэх баримт” болох анхан шатны баримтыг хөтөлж, хүлээн авсан акт үйлдсэн сайн талтай байна.

АРАВ. ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ТҮҮНИЙ ШАЛТГААН, ЗӨРЧИГДСӨН ХУУЛЬ, ТОГТООМЖ

1. Багш, ажиллагсдын 4-р улирлын ажлыг үнэлж дүгнэн, бага, дунд ангийн сургалтын менежер албан хаагч нэг бүрээр урамшуулал олгох хувийг нэгтгэж гаргасан байна. Үр дүнгийн урамшууллыг олгохдоо бага ангийн 12 багшид 30%-56%-иар үнэлсэн ч олгохдоо 60%-иар, бага ангийн 2 багшид ажлын үнэлгээгээр урамшуулал олгохгүй байхад 20%-40%-иар, сургалтын менежер, нийгмийн ажилтан, дунд ангийн багш нийт 26 багшид 22%-52%-иар үнэлсэн ч олгохдоо 40%-60%-иар, дунд ангийн сургалтын менежер, захиргаа аж ахуйн ажиллагсдын ажил дүгнэсэн үнэлгээний жагсаалт санхүүгийн баримтад байхгүй урамшууллыг олгохдоо сургалтын менежерт 60%-иар, захиргаа аж ахуйн бүх ажиллагсдад 45%-иар тооцож Сургуулийн захирлын 2018 оны 12 сарын 19-ний өдрийн Б/61 дугаар тушаалаар нийт 20,481.2 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулалт цалин олгосон, уг үр дүнгийн урамшууллаас 37 албан хаагчаас тус бүр 60.0 мянган төгрөг, 26 албан хаагчаас тус бүр 50.0 мянган төгрөг нийт 3520.0 мянган төгрөгийг суутган, энэ суутгалаас 2520.0 мянган төгрөгийг 2018 оны 12 сарын 21-ний өдрийн 362 тоот төлбөрийн хүсэлтээр Орхон аймгийн иргэн Мядагмаагийн /барилгын

материалын дэлгүүрийн худалдагч/ хувийн харилцах 5096216569 дугаар дансанд, 1000.0 мянган төгрөгийг 2018 оны 12 сарын 24-ний өдрийн 367 тоот төлбөрийн хүсэлтээр Хялганат тосгоны Хялганат зам ХХК-ийн 5286067155 дугаар дансанд шилжүүлж зарцуулсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.5, 13.6, 13.7-д заасан заалтуудыг хэрэгжүүлээгүй.

2. Тооллогын комисс нь ажилтан, албан хаагчдын эзэмшиж буй эд хөрөнгийг “Эд хөрөнгийн тооллогын бүртгэл” маягтаар гаргасан, тооллогын бүртгэлд хөрөнгө нэг бүрийн үнийг тавьдаггүй, нягтлан бодогч тооцоо бодсон акт үйлдээгүй.

3. Бараа материалд агуулахын бүртгэл хөтлөөгүй, хоол хүнс, үдийн цай, бараа материалын тайланг сар бүр шалгаж хүлээн авсан ч тооцоо бодсон акт үйлдээгүй.

4. Дотуур байрны хоолны цэс, үдийн цайны цэсийг санхүүгийн баримтанд хавсаргаагүй, үдийн цайны цэсийн дагуу материалыг олгоогүй тухайлбал 06 сарын 08-нд суралцагчдын үдийн цайнд боов, цай өгсөн байхад тогоочийн захиалга, няравын олгосон материалд 7.5 кг мах, 10 сарын 22-нд суралцагчдад гоймонтой шөл, цай өгсөн байхад тогоочийн захиалга, няравын олгосон материалд 4.3 кг цагаан будаа, 11 сарын 06-нд суралцагчдад бантан, цай өгсөн байхад тогоочийн захиалга, няравын олгосон материалд 20 кг гурил тус тус олгосон, 11 сарын 29-нд 286 суралцагчдын үдийн цайнд бууз, цай өгөхөөр тогооч 20 кг гурлын захиалга хийх байтал 30 кг-аар буюу 10 кг-аар илүү захиалга бичиж түүнийг нярав тавин олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.5, 13.6 дах заалтуудыг мөрдөж ажиллаагүй.

5. Орлон заасан хичээлийн хөлсийг сургуулийн захирлын тушаалгүйгээр олгодог.

6. Багш, ажиллагсдын цалин хөлснөөс Татвар, ЭМНДШимтгэл, цалингийн урьдчилгаанаас бусад 10,366.4 мянган төгрөгийн суутгал хийсэн нь Хөдөлмөрийн тухай хуулийн 63 дахь заалтыг зөрчсөн байна.

АВСАН АРГА ХЭМЖЭЭ, МЭРГЭЖЛИЙН ТУСЛАЛЦАА, ЗӨВЛӨГӨӨ ӨГСӨН БАЙДАЛ

Санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчийн 1 албан шаардлага үйлдэж, нягтлан бодогчид мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.

ДҮГНЭЛТ

Тус байгууллагын анхан шатны баримтын бүрдэлт, нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт хангалттай, санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр дотоодын хяналт хийсэн ажлын тайланг тухай бүрд нь үйлдэж, албажуулж архивлах шаардлагатай байна.

ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ

Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хуулийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах

Санхүүгийн үйл ажиллагаандаа дотоодын хяналт шалгалтыг тогтмол хийж санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх

Шилэн дансны тухай хууль, журам, захирамж, шийдвэрүүдийг хэрэгжүүлж биелэлтийг тооцож, хариуг улирал тутам бичгээр ирүүлэх

Илэрсэн зөрчлүүдийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх талаар анхааран тодорхой ажил зохион байгуулж, албан шаардлагын биелэлтийг албан тоотоор хүргүүлэх

БИЧСЭН:
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ Ж.ОЮУН

